



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 72

Чингис хот

Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн тухай

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 93 дугаар зүйлийн 93.1, 98 дугаар зүйлийн 98.1.4, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоол "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.3, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4-ийн б, Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журмын 2 дугаар зүйлийн 2.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 25 дугаартай тушаалд дараах өөрчлөлт оруулсугай.


1. Тушаалын үндэслэх хэсгийн "...Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3" гэснийг "...Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1" гэж,

2 Тушаалын 1 дэх заалтын "...Шагдарсүрэнгийн Отгонцэцэгийн өөрийнх нь хүсэлтийг үндэслэн 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн үр дүнгийн гэрээг цуцалж, төрийн албанаас чөлөөлсүгэй" гэснийг "...Шагдарсүрэнгийн Отгонцэцэг нь өөр ажилд орох болсон тул 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс уг албан тушаалаас чөлөөлсүгэй" гэж

Хоёр. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 25 дугаартай тушаалд өөрчлөлт орсон тул иргэн Ш.Отгонцэцэгийг Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын даргын 2018 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн Б/14 дугаартай тушаалын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын нөөцөд байгаа гэж үзсүгэй.

Гурав. Энэхүү тогтоолыг Өргөдөл хянан шалгах комиссын 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 64/01 тоот дүгнэлтийн хамт өргөдөл гаргагч Ш.Отгонцэцэг болон Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга /3.Ууганжаргал/-д хүргүүлэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /4.Болормаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР